

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 06/268

НШУС

2006

МОНГОЛ СОНИН СЭТГҮҮЛИЙН БУЙ БОЛЖ ХӨГЖСӨН ШАЛТГААНЫГ ЗАДЛАХ НЬ

Бү вэн*

* Өвөрмонголын их сургуулийн багш, доктор (Ph.D.)

Хөрвүүлсэн: Л.Норовсүрэн.

Түлхүүр үг: «Шинэ бодлого», аж ахуйлал, «Нялх сонин», шинэ маягийн сургуулиуд.

Харчин чин ван Гүнсэноров (1872-1930) 1898 онд Харчин баруун хошууны засаг чин вангийн тушаалд гарсаны дараа феодалын илжирмэл дүрэм горимуудыг эвдэн, ордны боол зарцыг чөлөөлжээ.

Тэрбээр дэс хуваах, дүрмийг үгүйсгэж бүх ард эрх тэгш дүрмийг хэрэгжүүлсэн байна. Түүний үзлээр ноёд түшмэд бол баатарчуудын үрс, боол зарц бол тэдгээр баатарчуудын ах дүү нарынх нь хойчис, бүгдээр дээдэс нэгтэй байж, ноён, боол гэж ялгах нь зохисгүй. Хүний биеийн гарлаар эрхэм, доордыг, ялгах биш, эрдэм чадвар сурсан бол сая эрхэм дээд юм гэж үздэг. Тэр, боол зарцын хүүхдийг, ч эрдэм чадвартай л бол адилхан хүндэтгэн хэрэглэнэ гэж тогтоожээ¹.

1901 онд юан ши хайн танилцуулгаар даавуулаг бодисын нөхцөлөөр Бу дин-гийн зэвсэгт хүчний бэлтгэл сургуулиас шилдэг хэр бүтэмжээр төгсгөсөн же цүн пэн-ийн цэргийн сургагчаар оржээ. Тэгээд хошууныхаа нэг бүлэг идэр чийрэг залуучуудыг уулын вангийн ордны хамгаалагч цэрэгтэй хамт нэгэн салаа жинхэнэ цэрэг анги болгон байгуулжээ. 1902 онд тэр бадаргуулт төр хаанд «амуу бэлтгэн, цэрэг боловсруулж, хууль тогтоох» бодрол өргөжээ.

1904 онд Алшаа торгууд Жиюүн ван пэлд-ээс бадаргуулт төр хаанд том сургууль эрхлэх, сонины хороо байгуулах, аймгийн даргыг бүгдээр сонгох, ламын шашныг хязгаарлах ... гэх мэтийн «Монголын шинэ бодлогын явдлыг төсөвлөх 12 зурвас» айлтгалыг дэвшүүлжээ.

Энэ нь түүний сурган хүмүүжлийг чухалчлан, үндэстнээ сэнхрүүлэхийг зорьж байсныг харуулав.

17 дугаар вангийн сууринд гарсан Биндү ван Гончигсүрэн цэрэг цагдаа зохион байгуулж, сургууль эрхэлжээ. Тэр цэргээ дагуулан хошуунд нь халдсан япон цэргийг үлдэн хөөж байсан удаатай.

1909 онд Биндү вангаас бадаргуулт төр хаанд айлтгал өргөж, шашныг хязгаарлан, мухар сүсгийг арилгах, сурган хүмүүжлийг хөгжүүлэн ард иргэнийг сэнхрүүлэх, цэрэг боловсруулан хязгаарыг бататгах, газар сонгон хагалбарлаж амьдралыг сайжруулах зэрэг саналаа дэвшүүлсэн байна. Бинтү ван бас эл улсын тариалах мэргэжилд байцаалт хийж тухайн газартаа зохицуулан туршин хагалбарлах, уурхай нээн компани байгуулах, үндсэн хуульт засгийг хэрэгжүүлэх зэрэг зорилттой байсан билээ.

Харчин хошууны Хайсан гүн бага наснаасаа монгол, хятад, манж хэлд зуван еован шалгаруулахаар чармайж өнгөрчээ. Тэр, бээжин дэх нэгэн вангийн ордонд ажиллаж, залуу үедээ дээд тушаалтны хэр (хэргэм) хэмийг олсон байжээ. Тэр бас л Хун Зэнгийн монгол бичээчийн ажлыг хийж байв. Сүүлээр нь тэр Орост чиглүүлсэн тагнуулын ажлыг ч хийж өнгөрчээ. Хайсан гүн олон улсын хоорондох байдал ба Монгол орны байдлыг нарийн ойлгож байсан учир тэр

урьд хожид ная гаруй монгол ван гүнтэй уулзан, тэдэнд монголын улс төрийн байр суурийг ойлгуулахаар чармайж байжээ. Гэтэл эдгээр ван, гүнгийн зарим нь мэдлэггүй, зарим нь өөрийн нэр хүндээ нэг мөсөн алдсаны учир асуудлын хүнд ноцтой чанарыг ойлгохгүй байлаа гэж Хайсан гүн ярьж байсан билээ.

Хайсан гүн Чин улсын, монгол оронд үйлдсэн ялт ажиллагаануудыг олон улсын шүүх танхимд заалдан шийдвэрлүүлэхээр зорьж байсан нь түүний дэлхийд чиглэгдсэн өргөн харааг харуулсан юм. Энэ нь мөн ч тухайн үеийн монгол сэхээтний үзэл санааны өндөрчийг харуулж байна.

Бусад олон ван гүн нар ч тус

тусдаа айлтгал өргөж монголын үндэсний соёл гэгээрлийг чухалчлан ард түмний сэхээрч ухаарахыг хүсэмжилсэн нь тэдний нийтийн онцлог мөн. Эдгээр хүмүүс сонин сэтгүүлийн үндэсний соёл гэгээрэлд үзүүлэх үйлдлийг таниж олсон байна.

Монгол сэхээтнүүдийн өөрсдөө сонин эрхэлсэн буюу эл улс төрийн бүлэгтний эрхэлсэн сонин хооронд идэвхтэй ажиллаж байсан нь яг энэхүү танилтын нөлөөнөөс болжээ. Жишээлбэл: 1905 онд Гүнсэнноров «Нялх

«

Хайсан гүн Чин улсын, монгол оронд үйлдсэн ялт ажиллагаануудыг олон улсын шүүх танхимд заалдан шийдвэрлүүлэхээр зорьж байсан нь түүний дэлхийд чиглэгдсэн өргөн харааг харуулсан юм. Энэ нь мөн тухайн үеийн монгол сэхээтний үзэл санааны өндөрчийг харуулж байна.

»

сонин»-ыг үүсгэн эрхэлсэн, Хайсан гүн "Монголын сонин бичиг"-ийн зохион байгуулах ажилд оролцсон бөгөөд найруулагчаар ажиллаж байсан биндүван Гончигсүрэнгийн нөлөөгөөр хүртсэн Буянмандах, Хэшингэ зэрэг хүмүүс сонин сэтгүүлд идэвхтэй ажиллаж байсан нь бүр ч энэ үеийн үндэсний сэхээрүүлэх үзэл санааны нөлөөллөөс болсон билээ.

Шинэ маягийн сургуулиуд байгуулагдаж сурган хүмүүжлийн түгээмэлжсэн нь

Ард түмний оюун ухааныг нээгдүүлж, соёл гэгээрлийг хөгжүүлэхэд сурган хүмүүжил хамгийн чухал гэдгийг ойр үеийн сэхээтнүүд ухааран мэдсэнээс Монгол оронд сурган хүмүүжил эрхлэх өрнөлт гарчээ. XX зууны эхээр палд жиюун ван «Монголын доройтсон нь монголчуудын оюун мэдлэг үгүйгээс болсон биш, харин оюуныг нээгдүүлсэнгүйгээс болсон юм. Иймээс ард түмний оюуныг нээгдүүлэх нь одоогийн хамгийн тулгамдсан шаардлага мөн» гэж үзэн сурган хүмүүжлийн үйлдэл болно.

Иймээс эл хошуу бэлэн монгө хуримтлуулан олон бага сургууль байгуулж, хүүхэд дүү нараа сурган хүмүүжүүлэх хэрэгтэй. Сурлага төгсгөсний дараа шалгалтаар дамжин шилдэг сурагчдыг нийслэлийн сургуулиудаар суралцуулбал зохино» гэжээ. Монгол үндэстний ойр үеийн сурган хүмүүжлийн үйлсэд лут их зүтгэл

үзүүлсэн хүн бол мөн харчин чин ван Гүнсэnnоров болно.

Гүнсэnnоров чин ван бүтэн нэг жил нарийн хянамгай бэлтгэл хийсний дараа 1902 оны 10 дугаар сарын 31-ний өдөр төвийг эрхэмнэх сургуулийг байгуулжээ. Тэр мөрний Өмнөдийн нэрт эрдэмтэн Лу Жиюун Лүвэй, Циен дүн (умрааш дайлах дайны үе Бээжингийн эртний хуучсыг дэлгэн үзүүлэх газрын даргаар ажиллаж байжээ)-ий 14 ерөнхий сургагчаар урьж, Цэн ан-ийг хятад сургагч, фу бү жэй-г монгол сургагчаар тус тус томилсон байна. Тэгээд 11 дүгээр сарын 1-ний өдөр сургууль эхлэх ёслол хийж, жинхэнээр сурлага эхэлжээ. Ёслол дээр Гүнсэnnоров: «Би вангийн хэргэмийг зүүж, баян эрхмийг эдлэн санаанд таарахгүй зүйл гэж үгүй. Гэтэл би энэ насандаа ер өнөөдөр шиг баярлаж өнгөрсөнгүй билээ. Учир нь өнөөдөр би өөрийн хошууныхаа хүүхэд дүү нарын сургуульд орж сурган хүмүүжил хүртэхийг нүдээрээ үзнэ, ирээдүйд бид хүн бүхэн Чингисийн үеийн аугаа үйлсийг сэргээх үүргийг үүрэглэх болно»² гэжээ.

Сургууль анх эхлэх үед сурагч, хоёрхон ангитай байжээ. Хүмүүс хүүхдээ сургуульд өгөх дургүй байлаа. Гүнсэnnоров зүйл бүрийн арга хэмжээ авч сурагчийн тоог нэмэгдүүлснээс 1903-1912 оны хооронд сурагчийн тоо тасралтгүй нэмэгдэж уулын 250-иасаа 400 гаруй болжээ. Хамаг олон үедээ багшийн анги, аж үйлсийн ангийг багтаасан 10 ангитай болсон билээ. 1912 он хүртэл нийт 600

гаруй сурагч тус сургуулиас сурлага төгсчээ. Шилдэг хир бүтээмжээр төгссөн сурагчдыг Бээжин, Тяньжин, Шанхай Будин зэрэг газар ба Япон улсуудад томилон дэвшсэн үзэл санаа ба тэргүүний шинжлэх ухаан мэргэжлийг суралцуулж байжээ. 1909 оны 3 дугаар сард Гүнсэноров Японд нууцаар айлчилж Осакид болсон дэлхийн 5 дугаар удааны дэлгэн үзүүлгийг тойрон үзээд Японы улс төр, сурган хүмүүжил, аж үйлдвэр, цэргийн бэлтгэл зэрэг байдалд гүнзгий байцаалт хийжээ. Тус жилийн зун тэр доорд дэсийн цэргийн ноёныг хүмүүжүүлэх зорилгоор ноёд түшмэдийн хүүхэд дүү нараас 30-ыг сонгож «Төвийг хамгаалах» цэргийн сургууль байгуулав. Цэргийн сургуульд Японы хуурай замын цэргийн хоёр ноёныг сургагчаар урьж Японы цэргийн дүрмийг хэрэглэн Япон хэлээр хичээллэжээ. Гүнсэноров цэргийн сургуулиасаа гурван шилдэг цэргийг сонгож Бээжингийн Дүн жиюү мин сиен гудамж дахь Японы цэргийн хороонд хүргэн боловсруулжээ.

Гүнсэноров Японд айлчилж байх хугацаандаа Токио дахь «Үйлдэлгэ охидын сургууль»-ийн дарга Ситатакитай уулзан ярилцаж охидын сурган хүмүүжлийн чухал чанарыг таниж олжээ. Тэгээд тэр, улсдаа буцсаны дараа охидын сургууль байгуулах ажлаа шуурхайлан хийжээ. 1903 оны 12 дугаар сарын 28-ны өдөр сургууль жинхэнээр эхлэв. Сургууль эхлэх үед вангийн хүүхэн дүүг багтаасан ордны хүүхэнчүүдийг

нэмээд нийт 24 сурагчтай байлаа. Билгийн улирлын цагаан сар болсны дараа сурагчийн тоо нэмэгдэн 60 болжээ. Гурван дэс хуваан хичээллэх болов. Сургуулийн явдлыг вангийн хатан өөрөө хамаарч Бат-Очир монгол хятад ерөнхий сургагч, Бээжингийн нэгэн зуван еовангийн хүүхэн зэн хатан хятад хэлний багш, Японоос ирсэн Кавара Мизаку Япон хэл, тоо бодлого, гар урлал, зураг, дуу, тамирын багшаар тус тус ажиллаж байжээ.

Гүнсэноровын байгуулсан эдгээр сургуулиуд үлэмж тооны бичигтнийг хүмүүжүүлснээр үл барам бусад хошуу, аймгийн сурган хүмүүжлийн үйлсд ч агуулах үйлдэл үзүүлсэн билээ. Харчин хошууны нөлөөлөл дор хорчин зүүн гарын өмнөд, хойт хоёр хошуу, хорчин баруун гарын дундад хошуу, хорчин баруун гарын өмнөд хошуу, хүрээ хошуу Хармөрөн мужийн харьяаны аймаг хошуу, Хөлөн буйрын найман хошуу жич хува зөн түмэд зэрэг хошуунуудад урьд хожид шинэ маягийн сургуулиуд байгуулагджээ.

Үүнээс гадна нэг бүлэг сэхээрсэн ван гүнгийн чармайлгаар манж Монголын дээд сургууль, хуурай замын цэргийн Гүй вэй сургууль, хуурайгийн цэргийн зурж төлөвлөх сургууль, Гүй вэй сургууль, манж монгол дунд сургууль, хязгаарын ... Биеэн сургууль фен дияны монгол сургууль, манж монгол дунд сургууль, монгол бага сургууль. Гирн мужийн манж-монгол дунд сургууль, манж-монгол багшийн сургууль хятад

хэл ба ойр үеийн шинжлэх ухаан техник мэргэжлийг заан сургах болжээ.

Эдгээр сургуулиудын байгуулагдсан нь эгэл ардын хүүхэд дүү нарт сурган хүмүүжил хүртэх тохиолыг олгож өгчээ. Ийнхүү монгол оронд бичиг соёлтой хүмүүс нэмэгдэн, утга соёл маш хөгжилттэй болсон байна.

Гүнсэнноров бас англи хэлний галигийг хэрэглэж унших дүрэм, сурахад хялбар монгол үсэг зохиож, хошуундаа сурган хүмүүжлийг түгээмэлжүүлэн соёлын балайг арилгахаар чармайж байсан юм. Сонин сэтгүүлийн тархаагдах хэмжээ нь тухайн орны сурган хүмүүжил түгээмэлжсэн хэмжээтэй шууд холбоотой байдаг.

Соёл, сурган хүмүүжил ихээхэн хөгжсөн өнөөдөр ч хараахан ийм байна. Иймээс тухайн үед соёл сурган хүмүүжсэн зохих хэмжээгээр хөгжин түгээмэлжиж, бичиг соёлтой хүн нэмэгдсэн нь монгол сонин сэтгүүлийн үүсэл хөгжлийн хамгийн чухал нөхцөл болжээ.

Монгол оронд таваарын аж ахуй хөгжсөн ба ойр үеийн аж үйлс бүрэлдсэн нь

Хар тамхины дайны дараа хаант орос умар зүгээс, япон өмнө зүгээс аж ахуйн нэвчилтээ чангатгажээ. Үүний дээр Чин улсын засгийн газар ч «Шинэ бодлого»-оо хэрэглэж монгол оронд их хэмжээний атар хагалбарлажээ. Үүний үр дүнд нэг талаар монгол орны аж ахуй

нэг мөсөн сүйрэх хэмжээнд хүрч, монгол орон урьд өмнө гараагүй хямралд оржээ. Нөгөө талаар монгол оронд тариалан аж ахуй дэлгэрч, таваарын солилцоо маш түргэн хөгжилтэй болсон байна.

1893 он болоход Хөххотын бөс нэхмэлийн зах дэлгүүрт бараг гадаадын бараагаар дүүрсэн байлаа. Үүнээс гадна бас цаг, дэн наадмын зүйл, эмэгтэйчүүдийн засал зэрэг зүйл бүрийн амьдралын хэрэгслүүд борлуулагдаж байлаа.

1861 онд Монгол орон дахь анхдагч Орос худалдааны компани байгуулагдаад удсангүй Ховд, Улиастай зэрэг газарт ч худалдааны газар гарч, Халганд суугаа орос худалдаачин 300-400-д хүрчээ. 1861 онд оросын ирэлцээ 21,1 түмэн рубль хүрчээ. Хоёрхон жилийн дараа 60 түмэн рубльд хүрч, 1885 онд 170 түмэн рубль. 1890 онд 690 түмэн рубль болон нэмэгдэж 40 жилийн хооронд 80 дахинаар нэмэгдсэн байна. Хаалга дахь Орос худалдаачны хөрөнгө мөнгө 3600 түмэн рубльд хүрчээ. 1904 онд Хаалга дахь орос цайны пүүс 8 болж, Хаалга дахь хувийн цайны зах дэлгүүрийг ганцаар эзэрхэн Хаалганд байнга суудаг Оросууд 10 түм гаруй болсон байна. Улиастай, Ховд, Гүй хувацэн, Зэн жиен ... Долнуураар Жирим аймгийн Гэгээн сүм, Хөлөнбуйрын Ганжуур сүм зэрэг сүм хийд, хот балгадаар орос худалдаачид тасралтгүй орогнож орос хийцтэй бараа таваар Монгол орон даяар түгжээ.

Харин аж ахуйн нэвчилтийн нөлөөлөл дор Монгол ван гүн нар

хөтлөлцөн өөрснөө аж үйлс эрхлэв. 1904 онд Харчин чин ван Гүнсэнноров вангийн ордны зүүн талд нэгэн ерөнхийлсөн чанартай үйлдвэр байгуулав. Тус үйлдвэр нь бас нэхэх, будаг суулгах, эсгий, саван, лаа, будаг үйлдвэрлэх салаатай Тяньжин дахь умардын аж ахуйллын газар суралцаад буцаж ирсэн сурагчид тус үйлдвэрийн голлогч мэргэжилтэн болсон байна.

Гүнсэнноров Тяньжингээс нэгэн ажилчин урьж хивс нэхэхийн хамт олон тооны монгол залуучуудыг шавь ажилчнаар мэргэжил сургаж байжээ. Тэр, Бээжин дэх дундад улсын Душвен банкаас гурван түмэн лан мөнгө зээлэн вангийн ордны баруун талд «Сан эй еэн хан» хэмээх бүрэн бараат дэлгүүрийг нээв. Дэлгүүрт

тус хошууны үйлдвэрийн бүтээгдэхүүнээ борлуулахаас гадна Бээжин, Тяньжин зэрэг газраас оруулсан тухайн газар орны монголчуудын амьдралд хэрэгцээтэй эд бодисыг худалдаж байлаа. Тус дэлгүүрийн эд бараа хол ойрд алдаршин зуу гаруй газрын алсаас наймаа хийж байв.

Харчин хошуу орчмоор таваарын солилцоо хөгжиж «Бага Бээжин» гэсэн нэртэй байжээ. Харчин хошуунд чимээ харилцаа дөхөмгүй байсан нь гаднах

дэвшсэн оронтой харилцахыг ихээхэн харшилж байжээ. Энэ байдлыг бүрэн ойлгосон Гүнсэнноров өөрийн биеэр хяналт тавин уулнаас их хэмжээний нарсан мод унагаж, хошуунаасаа 90 газар зайтай вэй цэн сиен-ээс мэдээний утас татаж, ингэснээс харчин хошуунд бүх улсын эл газрын цахилгаан мэдээ цөм нэвтрэх болсон байна.

Гүнсэнноров чин ван, гурван хүдэр чийрэг монгол залууг сонгон гурван ээлж, хувааж Бээжин ба Харчин хо-

шууны хооронд шууданч болгожээ. Бас шуудан орлон гүйцэтгэх товчоо, цахилгаан мэдээ хураах газар байгуулж, тусгай хүн томилон хамааруулав. Тогтмол хугацаат шуудантай болсноор Харчин хошууны багш, сурагчид их хэмжээний ном бичиг

захиалан уншсанаар үл барам Бээжинд гарч байсан сонин сэтгүүлийг ч уншиж дийлэх болов.

1905 оны 11 дүгээр сард Харчин дундад хошууны хүн Өнөбаяр, Фуде шин, хөрөнгөт аж ахуйллын шинж чанартай «Сиян иуй мод таримлын компани» байгуулжээ. Тус компани нь Цоорын голын дээд урсгалд байрлаж, Их хяangan давааны дундад хэсэг дэх Солонго уулын модон материалыг нээн ашиглаж байв. Хувь оруулсан нь бүр

«

Гүнсэнноров чин ван шуудан орлон гүйцэтгэх товчоо, цахилгаан мэдээ хураах газар байгуулж, тусгай хүн томилон хамааруулав.

Тогтмол хугацаат шуудантай болсноор Харчин хошууны багш, сурагчид их хэмжээний ном бичиг захиалан уншсанаар үл барам Бээжинд гарч байсан сонин сэтгүүлийг ч уншиж дийлэх болов.

»

монгол хүн байв. «Сиян иуй мод таримлын компани» бол хувийн аж ахуйлал болохыг мэдэж болно. Тус компани монгол үндэстний түүхэн дэх хамгийн анхны хувь хүний эрхэлсэн ойр үеийн хөрөнгөт аж ахуйлал буюу аж ахуйллын нэг болно. Фү де шен, Өнөбаяр ч монгол үндэстний ойр үеийн түүхэн дэх анхдагч хувийн хөрөнгөт аж ахуйлалтын болжээ.

Ойр үед монгол үндэстний өөрсдөө байгуулсан аж ахуйллын дотор «Монголын аж үйлсийн компани» нь нөлөөгөөр хамаг их байдаг. «Монголын аж үйлсийн компани»-ийн гол үүсгэн байгуулагч нь Хорчин зүүн гарын Хойт хошууны засагчин ван Амарлингуй болно. Халхын сайн ноён аймгийн Наяант чин ван, Харчин чин ван Гүнсэнноров, найман чин ван сүжигт баатар зэрэг Бээжинд суугаа ван гүн нар ч тус компанийг үүсгэн байгуулах ажилд оролцжээ.

Тус компани Монгол орны зам нэвтэрлэгийг нээн хөгжүүлэхээс гардан хийхээр төлөвлөжээ. Энэ тэргүүнд Зэн жиен кеу-ээс хүрээ хүрэх машин тэрэгний зөөврийн үйлсийг нээнэ. Зэн жиен кеу-ээс Сүйеован хүрэх төмөр замыг зассаны дараа Хүй Говэ цэн-ийн ойролцоо Лу хэ ке-ээс Хатан голын Нин шиан-д хүрэх усан замыг нээнэ, зам харилцаа хөгжсөн суурин дээр бусад аж ахуйллыг хөгжүүлнэ. Компанийн бэлэн мөнгө хуримтлуулж эзэгнэх арга, сан хөмрөгөөс 100 түмэн лан мөнгө гаргаж нэг түмэн хувь хуваана, хувь бүр 100 лан, үүнд 2000 хувь (20 түмэн лан)-г

үүсгэн байгуулагч ван, гүн нар худалдан авна. Үлдсэн 8000 хувь (80 түмэн лан)-г бүх улсын хэмжээн дэх хувь оруулагчидад худалдана.

1910 оны 10 дугаар сарын 12-ны өдөр «Монголын аж ахуйллын компани» Бээжинд өвтэгш их нээлтийн ёслол хийж жинхэнээр байгуулагджээ. Тус компани Монгол орны зам тээврийн үйлсийг нээн хөгжүүлсний хамт хойт Горлос хошууны атар хагалбарлах үйлс ба үзэмчийн давсны үйлсийг ч эзэгнэж байлаа.

Сонин сэтгүүлийн мэндлэх нь зохих бодисын суурьтай байхыг шаарддаг. Сонины цаас, хэвлэх мэргэжил гэх мэтийн бодисын нөхцөл нь сонин мэдээллийн үйлсэд дутагдаж болохгүй юм. Тэгвэл чанар бол сонин мэдээний өртгийг баталж байдаг. Сонин сэтгүүлийг эрх биш хамаг охорхон цагийн дотор уншигчийн гарт хүргэх хэрэгтэй. Үүнд хөгжсөн зам харилцаа тун чухал байдаг юм. Харийн аж ахуйн нэвчилт болон Монголчуудын өөрсдөө эрхэлсэн хөрөнгөт ёсны шинжтэй аж үйлс нь Монгол орны таваарын солилцоог түргэтгэж, нийгмийн эд бодисын баялгийг нэмэгдүүлсэн байна. Энэ нь монгол сонин сэтгүүлийн мэндлэхэд бодисын нөхцлийг бүрэлдүүлжээ.

Харийн түрэмгийлэл нь Монгол орон дахь аль олон зөрчил мөргөлдөөнийг улам хурцатгажээ

Аль эрт ХҮИ зууны үеэс эхэлсэн хаант оросын монгол орон дахь

түрэмгийлэл нь хар тамхины дайны дараа улам чангарсан байна. Хаант Оросоос Чин улсад тулгасан тэгш бус гэрээнүүдээр дамжин Дундад улсаас урьд хожид 140 гаруй түмэн дөрвөлжин километр нутаг дэвсгэрийг булаан эзэлжээ. Үүний хамт бас консулын таслан шийтгэх эрх, худалдааны танхим байгуулах зэрэг маш олон онц эрх олгосон байна.

«Б ээжингийн гэр»-т Оросууд Монгол оронд өөрсдөө тэрэг унаа хөлөглөж, захидал чимээ, эд бодис зөөвөрлөж болно гэж тогтоожээ. 1863 оны 6 дугаар сард Хиагт дахьт Орос худалдаачин энэхүү зурвасыг үндэслэн Хүрээ, Зэн жиеэ Кве-ээр дамжин Бээжин орох тогтмол хугацаат шуудан харилцааг байгуулжээ. 1865 оны 10 дугаар сараас эхлэн энэхүү шуудан харилцааг алба-наас эрхдэх болжээ. Улсаас жил бүр 19.300 рублийн нөхвөр өгч байв. 1870 онд хэдийгээр энэ шуудан харилцааг "Оросын хамгаалал дорх хувийн аж ахуйлал" гэж нийтэлсэн боловч Оросын засгийн газраас жил бүр 17.600 рублийн зоос өгч байжээ.

Оросууд энэхүү шуудан шугамд хүрээ, Зэн жиеэ, Хве, Бээжин, Тяньжин зэрэг дөрвөн шуудан товчоо байгуулжээ. XIX зууны сүүлчээр хаант Орос «Төмөр зам ба банк»-ийн аргаар хөрөнгийн гаргалт ба эх баялгийн дээрэмдлэгээ улам чангатгажээ. 1896 онд тогтоосон «Дундад-Оросын нууц гэрээ»-нд Оросоос бүхийлэн зүүн хойт орныг туулсан

«Алс Дорнодын төмөр зам» дэвсэхийг зөвшөөрчээ. Хаант орос зам дэвсэх ба хамгаалахын хэрэгцээ гэдгээр шалтаглан зам дагуу өргөн уудам газар орныг эзлэн, ой мод, уурхайн булагдацыг түр нээн ажиллажээ. Үүний хамт оросоос Дундад улс хамтрах нэрээр Дошвен ба их байгуулал Бээжин, Шанхай, Хурбанаас гадна Хайлаар, Манжуур, Хүрээ, Улиастай зэрэг газарт хувиараа банк гаргажээ. Тус банк нь зоос тархаан зээллэг тавьж мөнгөн гүйлгээний зах дэлгүүрийг эзэмдэн Дундад улсын албаны зоосыг хавчин гадуурхаж байлаа.

1894-1895 оны Дундад-Японы хөх морин жилийн дайн ба Дундад-Японы «Бихэний гэрээ» тогтоосноос Японы, Дундад улс дахь түрэмгийлэл эхлэв. «Бихэний гэрээ»-нд Японоос Өвөрмонгол оронд арилжаа хийж, үйлдвэр байгуулахыг зөвшөөрөв. Японы Өвөрмонгол дахь түрэмгийлэл нь худалдаа, мал аж ахуйн гаралт, эд уурхай, аж ахуйлбарын түүхий материалыг ашиглахаар гол шинж тэмдгээ болгосон байна.

Энэ нь үнэндээ хаант Оросоос түүхий эдийн гаралтын орныг булаасан явдал болжээ. Ийнхүү Япон, Оросын хооронд эзэрхэх эрх булаалдсан тэмцэл гарч, эцэстээ 1904-1905 оны «Япон, Оросын дайн» үүсчээ. Англи, Америк зэрэг Өрнө дахины улсын бараа таваар Тяньжин гармаар дамжин Монгол орны зах дэлгүүрт орж ирсэн нь XIX зууны ерээд оны явдал болно. Эдгээр улсын эд бараа бүхүйлэн Монгол оронд тархаж, Орос, Японы бараатай өрсөл-

дөж байлаа. Ялангуяа нэхмэлийн зүйлс нь Өвөрмонголын зах дэлгүүрийг ганцаар эзэрхэж, Хаалгын зах дэлгүүрт Оросын бараатай өрсөлдөж байжээ.

Үүнээс гадна Монгол орны арьс, ноос зэрэг гаралт нь ч Тяньжингээр дамжин Англи, Америк зэрэг улсад борлуулагдаж байжээ.

Монгол орныг түрэмгийлсэн эдгээр харийн түрэмгийлэл нь Чин улсын Монгол орон дахь ноёрхлыг сулруулжээ. Ийнхүү Монгол орныг багтаасан бүх улс дахь ноёрхлоо бататгахын төлөө Чин улсын засгийн газраас XX зууны эхээр «Шинэ бодлого» гэгчээ хэрэглэжээ. Монгол оронд их хэмжээгээр атар хагалбарлан, дотор газраас их хэмжээний хүн амыг нүүлгэн авчирсан «Шинэ бодлого»-ыг хэрэгжүүлэн 10 жилийн дотор Чин-гийн засаг Өвөрмонголын баруун хэсэгт 330 гаруй түмэн шан атар хагалбарласан байжээ. Судлаачдын бүртгэлээр Чин улсын засгийн газар 1908 он болоход нэгэнт 670 түмэн лан гаалийн мөнгө хурааж, бусад элдэв зүйлийн гааль түрээсээ нэмээд нийт 1000 түмэн лангаас дээш мөнгө хураажээ.

Их хэмжээгээр атар хагалбарласнаас өргөн олон малчид үе улиран малжиж, ирсэн нутаг усаа алдан,

амьдрахын аргагүй болжээ. Монголын дээд давхаргын ашиг тусад ч ихээхэн хохирол учруулжээ. Ийнхүү үндэстний зөрчил урьд гараагүй хурцдаж, зэвсэгт мөргөлдөөн зөндөө гарч байжээ. Эзэрхэг түрэмгийтний хооронд, колоничлогч ба колони орны ард түмний хооронд явагдах эдгээр зөрчил тэмцлээр үндэстний зөрчил мөргөлдөөн нь сонин мэдээллийн үйлсэд илрэлээ олох нь лавтай юм. Эзэрхэг түрэмгийтэн колонийн төрийн бодлогоо хэрэгжүүлэхэд сонин сэтгүүл эрхлэн өөрийн сүр хүчний давуулгаа харуулах, өөрийн түрэмгийллээ зөвтгөх, колони орны ард түмнийг засгийн газартай нь хагацуулан биедээ та-

«

Гүнсэниоров чин ван шуудан орон гүйцэтгэх товчоо, цахилгаан мэдээ хураах газар байгуулж, тусгай хүн томилон хамааруулав.

Тогтмол хугацаат шуудантай болсноор Харчин хошууны багш, сурагчид их хэмжээний ном бичиг захиалан утисанаар үл барам Бээжинд гарч байсан сонин сэтгүүлийг ч уншиж дийлэх болов.

»

тахыг зорьж байв. Колони орны засгийн газар ч сонин сэтгүүлийг ашиглан харийн түрэмгийллийг илчлэн эсэргүүцэх, ноёрхлоо бэхжүүлэхийг ухуулж байв. Цөөхөн тооны хөрөнгөтөн ангийн сэхээтэн буюу эх оронч хүмүүс ч сонин сэтгүүл эрхлэх буюу сонин сэтгүүлийн ажил хийж нутаг орноо авран хөгжүүлэх, ард түмнээ сэнхрүүлж хүмүүжүүлэх арга замыг эрэлхийлж байжээ. Эдгээр адил бус улс төрийн бүлэгтэний хоорондох ээдрээ будлиантай зөрчил тэмцлээ ч өөр өөрийн адил бус зорилт нь нийгмийн

яриа хэлэлцээг хөөр хөгжөөнтэй болгох нь дамжиггүй. Энэ монгол сонин сэтгүүлийн мандуулан хөгжүүлсний шууд шалтгаан болжээ. Сонин сэтгүүл бол нэг үндэстний мандал доройтол, хувьсал хөгжлийн бэлгэ тэмдэг ба тусгал болдог. Тухайн үеийн Монгол үндэстний үзэл санаа, соёл сурган хүмүүжил, аж ахуй, улс төр зэрэг талын лут их түүхэн хувьсгалт нь сонин сэтгүүл дээр тусгагдахгүй байхын аргагүй юм. Колоничлогч заавал нийгмийн яриа хэлэлцээний дээд хэлбэр болох сонин мэдээллийн үйлсэд өөрийн тусгалаа олдог. Ойр үеийн монгол сонин сэтгүүлийн мэндлэх хөгжих нь түүхэн хөгжилтийн зайлшгүй хандаш болно. Өрсөлдөөн зөрчилдөж байгаа мөлчигч ба мөлжигдөгч, колонич-

логч ба колони орны хооронд улс төр, аж ахуй, цэргийн явдал зэрэг олон талын зөрчил урт хугацаагаар орших болно.

Эдгээр зөрчил тэмцэлд сонин сэтгүүл нь ухуулан дайчлах, гүтгэх дайрах зэрэг зүйл бүрийн үйлдэл гаргах бөгөөд энэхүү урт хугацааны өрсөлдөөн тэмцэлдээний дунд шинэ хөгжилтөө олдог юм.

Ойр үеийн Монгол сонин сэтгүүл бол ийм түүхэн цаг үеийн дүрдэс болно.

Ишлэл

¹ Гүнсэмноровын намтар. Улаан хадын соёл, түүхийн материал. Дөрөвдүгээр.

² Синфү Ли, Эвэнх «Гүнсэмноров». Улаан хадын соёл түүхийн материал. Дөрөвдүгээр.